

БАТЛАВ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Ч.МӨНХТУЯА

2024 оны 06 дугаар сарын 27 – ны өдөр

АГААРЫН ХӨЛГИЙН ШАТАХУУН ТЭЭВЭРЛЭХ ЧИРГҮҮЛИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Агаарын хөлгийн шатахуун тээвэрлэх чиргүүл нь ашиглалтын хувьд найдвартай, техникийн үйлчилгээ явуулахад хялбар байхын дээр цахилгаан болон хийн тоноглолын талаар хамгийн сүүлийн үеийн технологи ашиглан хийгдсэн байна.

Манай орны цаг агаарын нөхцөл нь жилийн дөрвөн улиралд огцом өөрчлөгддөг, агаарын хэм нь өвөлдөө -40°C , зундаа $+40^{\circ}\text{C}$ хүрч хэлбэлздэг тул чиргүүлийн эд ангиуд нь дээрх цаг агаарын нөхцөлд хэвийн ажиллагаатай байна.

Уг чиргүүл нь 2024 онд үйлдвэрлэгдсэн бөгөөд MNS 4598:2020, MNS 6889:2020, MNS4978:2020 стандартын шаардлагуудыг хангасан байна.

2. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үйлдвэрлэсэн он:	2024 оны /шинэ/
Зориулалт:	Шатахуун тээвэрлэх
Тэнхлэг:	Урд болон хойд тэнхлэгтэй, урд тэнхлэг нь хүрдэн жолоодлоготой байх
Тоормосны систем:	Хий, 4 дугуйнд тоормослох

3. ТОРХНЫ ҮЗҮҮЛЭЛТ

- Торхны багтаамж нь 10,000 литр;
- Торхны чемодан хэлбэртэй байх, 2 тусдаа тасалгаатай байх;
- Материал үл зэврэх гангаар хийгдсэн байх;
- Дотор тал нь үл зэврэх гадаргуутай байх, баталгаат хугацаа 5 жил;
- Торхны люкний хэмжээ нь диаметр нь 500-600мм, өндөр-400-600мм хэмжээтэй цэвэрлэгээ, үйлчилгээ хийх боломжтой, өндөр байх;
- Торхны тасалгаа бүр угийн хаалттай байх;
- Буух хоолойны үзүүрт үндсэн хаалттай байх;
- Люкний таг нь битүүмжлэлтэй, давхар хамгаалах тагтай байх;
- Амьсгалах болон хамгаалалтын хавхлагатай байх;
- Цалгианы хамгаалалтай байх;
- Түлшний түвшин заагчтай байх;
- Торхны дээд талд гарах, буух шаттай, торхны дээд хэсэгт үл халтирах гадаргуутай байх.

4. НЭМЭЛТ ТОНОГЛОЛ

- Цахилгаан тоноглолын утас, холболтууд ус болон зэврэлтээс хамгаалагдсан байх;
- Арын хэсэгт нэмэлт гэрэлтүүлэгтэй байх;
- Түлхүүр багажтай байх /дугуйн торцов болон түлхүүрийн ком/;

- Нөөц дугуйтай байх;
- Домкрат болон дугуйн ивүүртэй байх;
- Галын хортой байх /торхонд 2 ширхэг/;
- Газардуулгатай байх;
- Сумалгааны шлангтай сумалгаа хийх боломжтой, шилжүүлэгчтэй байх;
- Түлш шахах, сорох шугам, хаалт, буулгах хаалт нь стандарт холбогчтой байх;
- Бөмбөгөн хаалтнууд нь зэвэрдэггүй материалаар хийгдсэн байна.

5. ХҮЛЭЭН АВАХ

Нийлүүлэгч нь зөвхөн шаардлагад нийцсэн техникийн үзүүлэлтийг хангасан чиргүүлийг иж бүрдлийн хамт нийлүүлнэ.

ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу шалгаж, хүлээн авах актыг үйлдсэнээр чиргүүлийг хүлээн авсанд тооцно.

Баталгаат хугацаа нь ажил хүлээн авах комисс нь актад гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 12 сар.


Ачааг хүргэх цэг: Улаанбаатар хот, Буянт-Ухаа, Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба.

6. БУСАД НӨХЦӨЛ

- Ашиглалтын болон техник үйлчилгээ, засварын гарын авлага, сэлбэгийн каталоги монгол болон англи хэл дээр байх /Owner manual, Parts catalog, Service manual/.
- Нэмэлтээр сумалгааны шланг, люкны сальник, жийрэг, хувин-2 ширхэг зэвэрдэггүй материалаар хийгдсэн, сэлбэг материал тус бүр 1 ширхэг.
- Нийлүүлэхээр санал болгож буй чиргүүлийн үйлдвэрлэгч, загвар, зураг, техникийн үндсэн үзүүлэлтийг ирүүлэх.

Техникийн тодорхойлолт бэлтгэсэн:

Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах ажиллагааны тасгийн менежер,
Үнэлгээний хорооны дарга:

 Н.Эрдэнэбат

Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны дарга,
Үнэлгээний хорооны гишүүн:

 Н.Баттөр

“Инженер технологийн үндэсний төв” Төрийн бус байгууллагын гэрүүн,
Үнэлгээний хорооны гишүүн:

 Ч.Нямдаваа

“Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв” Төрийн бус байгууллагын гишүүн,
Үнэлгээний хорооны гишүүн:

 С.Байгалмаа

Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн,
Үнэлгээний хорооны нарийн бичиг:

 Б.Мөнхбаатар